


ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2024 ОНЫ ТАЙЛАН

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1	Хүний эрхийг хамгаалах, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагааг иргэд болон эмнэлгийн ажилтнуудад сурталчлах, соён гэгээрүүлэх	1.1 Хүний эрхийн Үндэсний Комисс болон Эрүүл мэндийн яамнаас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, гарын авлага зэргийг тухайн байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграмм Youtube суваг), лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх	Хүний эрхийг дээдлэх Хүчирхийллийн эсрэг аяны хүрээнд мэдээлэл бэлтгэн олон нийтийн цахим сүлжээнд байрлуулан ажилласан. 
		1.2 хүний эрхийг хамгаалах, зөрчихөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах,	УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН АЖИЛТНУУДАД ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ТӨСЛИЙН НЭЭЛТ ХИЙСЭН. НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 06 дугаар сарын 14 өдрийн 231 тоот тогтоолоор “Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)”-г батлаад байна.


			Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг дэмжих зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Монгол Улсын холбогдох яам, агентлаг, төрийн байгууллагуудад НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг сурталчлан таниулах, үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Энэ хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлэг НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр болон хүний эрхийн магадлан шинжилгээний төслийн багтай хамтран эрүүл мэндийн салбарт анх удаа ажилтнуудын эрхэд хүний эрхийн магадлан шинжилгээ хийх төслийг санаачлан эхлүүлээ. Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь ард иргэдийн хүсэл хэрэгцээнд нийцсэн, чанартай аюулгүй тусламж үйлчилгээтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, Монгол Улсын шилдэг эмнэлэг байхын тулд үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, НҮБ-аас баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас баталсан гэрээ конвенцүүдэд заасан хүний бүхий л эрхийг ХҮНДЭТГЭН ажиллахыг эрхэм зорилгоо болгож байна. Бид ХҮНИЙ ТӨЛӨӨ ХҮЧИРХЭГ БАГ эрүүл мэндийн салбартаа анхдагч болж байна.
--	--	--	--

			  
		1.3 Хүний эрхийг хамгаалах, зөрчихөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Хүний эрх” мэдээллийн самбар ажиллуулах	“Хүний эрх” мэдээллийн самбарыг тогтмол мэдээллийг шинэчлэн ажиллуулж байна. 

		1.4 Өөрсдийн үйл ажиллагааг хүний эрхийн зөрчлөөс ангид байхад чиглэсэн, уриалсан агуулга бүхий сурталчилгааг олон нийтэд хийсэн байх.	Хариуцлагатны ярианд эмнэлгийн орчинд эрх зөрчигдөх болон хүчирхийллийн талаар сургалт хийсэн.  
2	Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны онцлогт тохирсон мэдлэг, шинэ агуулга бүхий Хүний эрхий сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах	Байгууллагын удирдах ажилтнууд болон байгууллагын ажилтнуудыг хүний эрхийн сургалтад хамруулах	Хүний эрхийг дээдлэх Хүчирхийллийн эсрэн 16 хоногийн аяныг зохион байгуулан 11 сарын 25-аас 12 сарын 10-ны хооронд (Хүний эрхийн өдөр) Жендерт суурилсан хүчирхийллийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, охид эмэгтэйчүүдийн эсрэг хортой үйлдлүүдийг таслан зогсоох зорилгоор зохион байгуулсан. 68 эмнэлгийн эмч мэргэжилтэн сургалтад хамруулсан  
3	Хүний эрхийн зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	Хүний эрхийн Үндэсний Комисс болон Эрүүл мэндийн яамнаас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, зөрчил үүсэх болсон шалтгаан нөхцөлийг арилгасан байх	Нийт ажилтнуудын дунд болон эмнэлгийн үйлчлүүлэгч нартай хамтран Хүний эрх хэрхэн зөрчигддөг талаар өдөрлөг зохион байгуулсан.

Хүний эрхийг ханган ажиллаж буй байдлын талаарх сэтгэл ханамжийн судалгааг байгууллагын ажилтнууд болон үйлчлүүлэгчдээс судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлан холбогдох арга хэмжээг зохион байгуулах.

Сэтгэл ханамжийн судалгаа авч Дүгнэлт хийн ажиллаж байна. Үүнд: “Заримдаа”-20 хүнд дээр - Эмнэлгийн үйлчлүүлэгчид нийгэм маш стресстэй байгаа тул үйлчлүүлэгч нар эмч, эмнэлгийн ажилчидтай ёс зүй харьцдаг тул бид эмнэлэгтээ сэтгэл зүйч ажиллуулахаар төлөвлөөд байгаа болон нийт ажилчдад сэтгэл заслын сургалтын явуулж байна.



Үйлчлүүлэгч болон ажилтан хоорондын харилцааг сайжруулах талаар нээлттэй өдөрлөг зохион байгуулсан. Нийт 85 үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилтан хамрагдсан.

